



## ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 05

Эрдэнэт


┌ Талбайн хэмжээ, байршил, хил зааг, ┐  
зориулалтыг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е” дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Хот суурин газрыг “Дахин хөгжүүлэх төсөл” хэрэгжүүлэх талбайн хэмжээ байршил, хил зааг, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх төслийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг жил бүрийн IY улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ